



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 21 өдөр

Дугаар А/90

Улаанбаатар хот

Газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй
болгож, газар эзэмших эрхийг дуусгавар
болгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 4.1.4, 35 дугаар зүйлийн 35.3.1, 40 дүгээр зүйлийн 40.1.5, 40.1.6 дахь заалт, 39 дүгээр зүйлийн 39.1.4, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/253 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газрын тухай хууль, тогтоомж газар эзэмших гэрээний нөхцөл, болзлыг удаа дараа ноцтой зөрчсөн, төлбөрөө хугацаанд нь бүрэн төлөөгүй, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй 2 (хоёр) иргэн, аж ахуйн нэгжийн газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгож, газар эзэмших эрхийг дуусгавар болгосугай.

2. Энэ захирамжийн хавсралтад заасан иргэн, аж ахуйн нэгжийн газар эзэмших эрхийн гэрчилгээ нь хүчингүй болсон тухай зохих журмын дагуу мэдэгдэж, газар эзэмшүүлэх гэрээг цуцлан, газрын кадастрын мэдээллийн сангийн бүртгэлд өөрчлөлт оруулах, хяналт тавьж, ажиллахыг Багахангай дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайханд)-нд даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2012 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/78 дугаар захирамжийн Б.Булгамаа, 2016 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/219 дүгээр захирамжийн "Түмэн өрлөг" ХХК-д хамаарах заалтыг тус өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

АЖИЛ\ЗАХИРАМЖ

1123200329



Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 08 дугаар сарын 01-ны өдрийн
А.1.90 дугаар захирамжийн нэгдүгээр хавсрал

Газар эзэмших эрхийн гэрчилгээг нь хүчингүй болгож байгаа иргэн, аж ахуйн нэгжийн жагсаалт

Д/д	Газар эзэмшигч ашиглагч иргэн аж ахуйн нэгж байгууллагын		Газрын				Өмнө нь гарсан ДЗД-ын захирамж шийдвэр
	Нэр	Регистр	Байршил	Зориулалт	Хэмжээ м2	Эдэлбэрийн хэлбэр	
1.	Баатарболд Булламаа	УК95060108	1-р хороо, Өндөртолгой	Халуун ус, саун	1000	Эзэмших	2012 оны А/78
2.	"Түмэн өрлөг" ХХК	5858305	2-р хороо, Алсын худгийн баруун хойд талд	Фермерийн аж ахуй байгуулах	20000	Эзэмших	2016 оны А/219